



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2024 оны 05 сарын 24 өдөр

Дугаар 02

Сүхбаатар сум

«Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны» дүрэм, бүтэц орон тоонд өөрчлөлт оруулах тухай

Сангийн Сайдын 2019 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын хорооны дүрэм”-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтыг үндэслэн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны үйл ажиллагааг бэхжүүлэх, хяналт шалгалтын чанар, үр өгөөжийг дээшлүүлэхэд хүний нөөцийн оновчтой бодлогын хэрэгжүүлэхтэй холбоотойгоор бүтэц орон тоонд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг хорооны хурлаар хэлэлцээд ТОГТООХ нь:


Нэг. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дүрэм, бүтэц орон тоог баталсан аймгийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн А/75 дугаар захирамжийг шинэчлэн батлахыг дэмжсүгэй.

Хоёр. Бүтэц орон тоонд орсон өөрчлөлтийн дагуу шаардагдах төсвийн зардлыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхийг Санхүү төрийн сангийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Х.Мөнхжаргалд)-д даалгасугай.


Гурав. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан захирамжид нэмэлт өөрчлөлт оруулах төслийг холбогдох журмын дагуу боловсруулан баталгаажуулах, тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллахыг хорооны Нарийн бичгийн дарга (Т.Мөнхзул)-д үүрэг болгосугай.

Хорооны дарга  Н.Лхагвадорж
(Аймгийн Засаг дарга)

Нарийн бичгийн дарга:  Т.Мөнхзул
(Ахлах дотоод аудитор)

Гишүүд  Т.Одсүрэн
(Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга)

432400909



Ө.Сувдаа
(Аймгийн Засаг даргын
Тамгын газрын дарга)



Х.Мөнхжаргал
(Санхүү төрийн сангийн хэлтсийн
даргын албан үүргийг түр орлон
гүйцэтгэгч)



А.Дашбат
(Иргэний төлөөлөл)